



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/91

Халбан

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалт, 59.1.6, 59.1.11 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газраас олгосон мал эмнэлгийн ариутгал, халдваргүйтгэл, угаалгын зориулалт бүхий тусгай зориулалтын автомашин хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Бямбажав (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд: Ч.Бямбасүрэн (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Н.Бямбадорж (Засаг даргын Тамгын газрын жолооч)

Н.Доржжүгдэр ("Таг дүүрэн сүрэг" ХХК-ийн захирал, малын

их эмч)

Нарийн бичгийн дарга: Н.Алтанхуяг (Мал эмнэлгийн тасгийн дарга)

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олгогдож байгаа уг автомашины эзэмшил, ашиглалтыг сумын мал эмнэлгийн тасагт гэрээний үндсэн дээр хариуцуулж техникийн бүрэн бүтэн байдлыг нягтлан шалгаж хүлээж авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Бямбажав)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д даалгасугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

